

МОНГОЛ-ХЯТАДЫН СОЁЛ, БОЛОВСРОЛЫН ХАРИЛЦАА ШИНЭ ШАТАНД ХӨГЖИЖ БАЙНА

А.БАТЦЭЦЭГ*

Аливаа улсын тусгаар тогтнол гэдэг тухайн улсын өв соёл, зан заншил, ард иргэдийнх нь боловсролоор бэхэждэг бол хоёр улсын харилцаанд бие биенээ харилцан ойлгож, харилцан хүлээн зөвшөөрөхөд соёлын харилцаа чухал нөлөөтөй байдаг. Түүхэн баримтаас үзэхэд, Монгол, Хятад хоёр орны хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоосны дараа соёл, боловсролын салбарын төлөөлөгчид хоёр ард түмний найрамдал нөхөрлөлийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байв.

Эдүгээ Монгол-Хятадын соёл боловсролын салбарын хамтын ажиллагаа шинээр далайцтай хөгжих үе шатандаа шилжээд байна. Шинэ зууны Монгол-Хятадын харилцааг хөгжүүлэн бэхжүүлэхэд, ялангуяа харилцан итгэлцэл, ойлголцлыг бэхжүүлэхэд соёл, хүмүүнлэгийн салбарын харилцаа, хамтын ажиллагаа улам бүр чухал ач холбогдолтой болж байна. 1990-ээд оны эхэн үед хоёр орны харилцаанд улс төр, эдийн засгийн чиглэл давамгайлж, соёл, боловсролын салбарын харилцаа хамтын ажиллагаа харьцангуй удаашралтай байлаа.

Шинэ зуун гарсаар тухайн салбарын нөхцөл байдал өөрчлөгдөж, эрчимтэй хөгжих нөхцөл бүрэлдлээ. Даяаршлын эрин үед соёл

урлаг, боловсролын харилцаа нь нэг улс орны хүрээнээс давж дэлхийн оюун ухаант хүн төрөлхтөний нийтлэг харилцаа, тэдний оюун санааг холбон нэгтгэгч хүчин зүйл болж байна. Энэхүү харилцаа, холбооны эерэг сайн тал нь ойлголцол, найрамдал, хамтын ажиллагааг бий болгодог. Харин сөрөг тал нь жижиг улс үндэстний өвөрмөц байдал, өв соёл их гүрнүүдийн соёлын нөлөөнд автаж, доройтон буурах, үндэсний хэл соёл бүдгэрэн устах аюултай тулгардаг.

Сүүлийн үед шинжлэх ухаан-технологи, соёл, боловсрол, утга зохиол, эрүүл мэндийн хүрээн дэх солилцоо тасралтгүй нэмэгдсээр байна. 1983 онд Монгол Улсын чөлөөт бөхийн баг Хятадад айлчилсан нь хоёр улсын хооронд биеийн тамир спортын харилцаа 20-ид жил тасарсан байсныг сэргээжээ. Үүнээс хойш хоёр улсын эрүүл мэнд, биеийн тамир спортын хамтын ажиллагааны талаар олон гэрээ хэлэлцээр тогтоожээ. Монгол, Хятад хоёр улсын Засгийн газар хоорондын худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан-техник мэргэжлийн хамтын ажиллагааны зөвлөл 1989 онд байгуулагдаж, нийт 11 удаагийн ажлын хурлыг зохион байгуулжээ. Сүүлийн 20 гаруй жилийн турш Монгол, Хятадын шинжлэх ухаан техник мэргэжлийн салбар

* А.БАТЦЭЦЭГ- МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийн Дипломат орчуулгын Тэнхимийн багш, докторант

дахь хамтын ажиллагаа урагшлан хөгжиж, 2000 оноос эхлэн хоёр улсын шинжлэх ухаан техник мэргэжлийн байгууллага нь хил хязгаарын бүс нутгийн цөлжилтийг сэргээн засах болон эрүүл ахуйн судалгааны ажлыг хамтран хийсэн байна. 2006 онд Монгол Улсын Боловсрол соёл шинжлэх ухааны яам болон БНХАУ-ын Шинжлэх ухаан техник мэргэжлийн яамны хооронд 2006–2010 оны шинжлэх ухааны техник мэргэжлийн хамтын ажиллагааны гэрээ байгуулж, бодитой үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал: хоёр тал Монгол Улсад техник мэргэжил дамжуулах төв байгуулахаар хамтран ажиллав. Монгол Улсын нөхцөл байдалд тохирсон чанартай лууван тарьж ургуулах, ургамал судлал, бүрхэвч хамгаалалтын судлал зэрэг төслийг хамтран хэрэгжүүлжээ.

Монгол, Хятад хоёр улсын соёл боловсролын салбарын харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлсээр байна. Сүүлийн хэдэн жил “соёлын өдрүүд”-ийг хоёр талд ээлжлэн явуулж улмаар соёлын салбарын хамтын ажиллагааны хүрээнд улс тус бүрдээ олон улсын соёл урлагийн үйл ажиллагаанд харилцан төлөөлөгчийн бүрэлдэхүүнийг урин оролцуулсан байна. Монгол, Хятад хоёр улс хамтарч Монгол үндэстний уртын дууг ЮНЕСКО-д бүртгүүлсэн нь¹ хоёр улсын соёлын солилцоо болон хамтын ажиллагааг шинэ шатанд гарсныг харуулж байна. БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Оронд Хятадад оршин суух монгол үндэстний дийлэнхи олонхи нь төвлөрөн аж төрдөгийн хувьд Монгол Улстай соёлын солилцооны өргөн нягт харилцаатай юм. 2004 оноос эхлэн БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Засгийн ордон БНХАУ-

аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Монгол Улсын Боловсрол соёл шинжлэх ухаан яамтай хамтран цагаан сарын “Солонго энх мэндийн хадаг” гэсэн урлаг уран сайхны үзүүлбэрийг зохион байгуулсан нь Монгол, Хятадын соёлын солилцоо болон хоёр орны ард түмэн харилцан ойлголцох найрсаг харилцахад тааламжтай сайхан завшаан болжээ.

Ялангуяа сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хамтран оюутан сургах төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, Монгол Улсаас жил бүр 220 гаруй оюутан Хятадын Засгийн газрын урамшууллын мөнгийг хүртэх болжээ. Одоо Хятадын Засгийн газрын тэтгэлэг болон Өвөр Монголын Өөртөө Засах Орны Засгийн ордны тэтгэлэгээр 660 гаруй монгол оюутан Хятадын олон их дээд сургуульд суралцаж буй. Монгол Улсын их сургуулийн Күнзийн институт 2008 оны 6-р сард Улаанбаатар хотод байгуулагджээ. 2008 онд Хятадын 200 гаруй мянган иргэн Монголд зорчиж, Монгол Улсын 700 гаруй мянган хүн Хятадад зорчсон бөгөөд Хятадаар дамжин бусад улсад зорчжээ. Монгол, Хятад хоёр улсын Засгийн газрын 2004-2006 оны соёл урлагийн салбарт хамтран ажиллах ажлын төлөвлөгөөнд гарын үсэг зурснаар Монгол, Хятад хоёр орны соёлын арга хэмжээ улам бүр өргөн цар хүрээтэй болж, зохиогдож байгаа арга хэмжээ нь харилцан бие биеэ хүндэтгэх, тухайн улс орныхоо хэл соёл, зан заншлыг харилцан мэдэх нь хоёр улсын хооронд найрсаг харилцаа гүнзгийрэн хөгжихөд түлхэц болж, улмаар ард түмний найрамдлыг улам бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр болсоор байна. Монгол, Хятад хоёр

улс өөр өөрийн үндэсний өвөрмөц соёлоо хадгалан хөгжүүлэхийн зэрэгцээ соёлын талаар харилцан бие биедээ нөлөөлж, бусдын соёлын ололттой, давуу талыг шингээн авах нь сүүлийн жилүүдэд зохиогдож байгаа соёлын арга хэмжээнээс ажиглагдаж байна. Монголын ард түмний соёлын өвийн дээж болсон уртын дуу, хөөмий, морин хуур, уран нугараа, ардын биелгээ болон сонгодог дуурь, бүжгийн жүжгийн урын сангаас Хятадын ард түмэнд толилуулахын сацуу харилцан суралцаж байна.

Нөгөөтэйгүүр Монгол, Хятад хоёр улс монгол туургатны уртын дууг НҮБ-ын ЮНЕСКО-гийн хүн төрөлхтөний аман болон биет бус соёлын өвийн бүтээлийн жагсаалтад хамтран оруулсан нь хоёр улсын соёлын хамтын ажиллагааны түүхийг нэгэн шинэ хуудсаар баяжуулсныг дээр дурьдсан.² Ийнхүү жилүүдэд Монгол, Хятадын найрсаг харилцаа тасралтгүй хөгжсөнөөр соёл урлагийн албаны хүмүүс харилцан айлчлах, соёл урлаг, боловсрол, биеийн тамир болон бусад салбарын төлөөлөгчид харилцан зочлох тоо жилээс жилд улам нэмэгдэж байна. Хятад улсад зохиогддог олон улсын шинж чанартай соёл урлагийн арга хэмжээнд Монголын урлаг соёлынхон тогтмол оролцдог болсон. 2012 оны 2 дугаар сард хоёр улс соёлын өдрүүдээ харилцан зохион байгуулсан нь хоёр орны ард түмний эв нэгдлийн гүүр улам бэхжиж буйг харуулж байна.

Улсын болон хувийн зардлаар Монголд ирж суралцаж буй хятад оюутан, Хятад улсад суралцах монгол залуусын тоо жил бүр өсөн нэмэгдэж, хоёр улсын их дээд сургуулиудын харилцаа улам бүр өргөжиж байна. Ийнхүү хоёр орны их дээд сургуулиуд харилцаа

холбоо тогтоож эхэлсэн бөгөөд МУИС Хятадын Бээжин Их Сургуультай холбоо тогтоосны дараа УБИС, Хүмүүнлэгийн Их Сургууль, МУБ Их Сургууль зэрэг улсын сургуулиуд мөн түүнчлэн "Их засаг", "Отгон тэнгэр" зэрэг хувийн сургуулиуд Хятадын Бээжингийн Гадаад хэл соёлын их сургууль, Олон улсын харилцааны их сургууль, Ардын их сургууль, Даляний Гадаад хэлний дээд сургууль, Хэбэйн их сургууль, Хэбэйн ХААИС, Өвөр Монголын их сургууль, Өвөр Монголын Багшийн их сургууль, Зүүн хойд Хятадын багшийн их сургууль зэрэг сургуулиудтай холбоо тогтоосон байна. Энэ нь сургууль хоорондын уялдаа холбоог бэхжүүлж хоёр орны оюутан залуусын нөхөрлөл, сургууль хоорондын харилцаа, хөгжилд үр дүнгээ өгч байна³. Найрсаг харилцаатай хөрш улсынхаа соёлыг ойлгох, судлахын тулд тухайн орны хэлийг сурахаас эхлэх нь зүйтэй бөгөөд сүүлийн үед хоёр орны ард иргэд харилцан бие биеийхээ хэлийг сонирхон судлах, нутагт нь очиж суралцах явдал эрс нэмэгдэж байна⁴.

2010 онд Монгол-Хятадын хамтын ажиллагааны хэд хэдэн баримт бичигт гарын үсэг зурав. Үүнд:

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж БНХАУ-д төрийн айлчлал хийж, БНХАУ-ын дарга Ху Жинтао нарын албан ёсны хэлэлцээний дараа хамтын ажиллагааны зарим баримт бичгүүдэд гарын үсэг зурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр Хятадын Засгийн газраас Монгол Улсад олгохоор болсон 40 сая юаний буцалтгүй тусламжийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Эдийн засаг,

техникийн хамтын ажиллагааны хэлэлцээрт монголын талаас Гадаад харилцааны сайд Г.Занданшатар, хятадын талаас Худалдааны сайд Чэнь Дэмин нар гарын үсэг зурав⁵.

Мөн Улаанбаатар, Бээжин хотуудад харилцан соёлын төв нээх тухай Соёлын төв харилцан байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон соёлын солилцооны хүрээнд 2010-2013 онд хэрэгжүүлэх арга хэмжээний

тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 2010-2013 онд хэрэгжүүлэх Соёлын солилцооны төлөвлөгөөнд монголын талаас Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, хятадын талаас Соёлын сайд Цай У нар гарын үсэг зурсан байна⁶. Ийнхүү хоёр улсын соёл боловсролын харилцаа өдрөөс өдөрт шинэ шатанд гарч, үйл ажиллагааны хүрээ өргөжин тэлсээр байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. www.news.mn
2. Монгол Хятадын харилцаа жаранаас жаранд. УБ, 2010 А.Батцэцэг
3. www.news.mn
4. www.google.mn
5. Монгол Хятадын харилцаа жаранаас жаранд. УБ, 2010 А.Батцэцэг
6. www.google.mn